



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ



Төсөл, арга хэмжээний төлөвлөлт нэгдсэн бодлогын хүрээнд хийгдээгүй, он дамжин хэрэгжиж буй зарим ажлын гүйцэтгэл хангалтгүй, хүлээн авсан тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад бүртгүүлээгүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

2021 он



Тайланг бэлтгэсэн:		Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар		Бүлэг 1: Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүйгээс хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдсаар байна.
Дарга, аудитор	Тэргүүлэх	А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна. 6
	Б.Сарантуяа	А.2 Төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна. 7
Аудитын менежер	Г.Наранбаяр	А.3 Зарим төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төслийг төсвийн тухай хууль батлагдахаас өмнө боловсруулж, баталгаажуулаагүй байна. 9
	Ахлах аудитор	Бүлэг 2: Гүйцэтгэгч компаниуд хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй, захиалагч нь гэрээний үүргийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, хяналтын тогтолцоо оновчтой бус, хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.
Аудитор	Б.Дарханбат	Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан байна..... 10
	С.Батцэцэг	Б.2 Захиалагч гэрээний дагуу ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлээгүй, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллаагүй байна. 12
2021 оны 04 дүгээр сар		Б.3 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна..... 14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543151 дугаарын утсаар харилцана уу.		Б.4 Барьцаа хөрөнгө дансанд байршуулсан төсөл, арга хэмжээний санхүүжилт бүрэн олгогдоогүй, ашиглалтад хүлээн авсан тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна. 15
		Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар Хавсралтууд
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот		



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын их хурал
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БСШУСС	Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайд
ЗТХС	Зам тээврийн, хөгжлийн сайд
ТАХ	Төсөл, арга хэмжээ
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
МУНЭЗ	Монгол Улсын нийгэм эдийн засаг
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ЗГ	Засгийн газар
ХАА	Худалдан авах ажиллагаа



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/28 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу хийлээ.

2. Аудитын зорилт:

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймагт эрх шилжиж хэрэгжсэн “Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэхээр баталсан 19 төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамрууллаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан. Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817-1:2020 “Төрийн аудит Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор-нягтлан бодогч С.Батцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл



Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хөл хорио тогтоосон, аудитыг гүйцэтгэж байсан аудитор тусгаарлалтад орсон зэрэг нь аудитын талбарын ажилд хүндрэл учруулж байлаа.

8. Үндсэн мэдээлэл

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говьсүмбэр аймагт 33,090.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээ батлагдсанаас тайлант онд 14,360.8 сая төгрөгийн санхүүжилт баталжээ.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд нэр зааж батлагдаагүй буюу салбарын ТЕЗ-д батлагдаж эрх шилжсэн 281.4 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс шилжих 8, шинээр хэрэгжих 11 төсөл арга хэмжээ батлагджээ. Дээрх 19 төсөл, арга хэмжээний 15 нь Говьсүмбэр аймгийн ТЕЗ-д эрх шилжиж хэрэгжсэн бол 4 арга хэмжээ эрх шилжээгүй хэрэгжсэн байна.

Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газар, захиалагчийн хяналтыг Говьсүмбэр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймгийн Засаг даргын Тамгын газраас тус тус хэрэгжүүлэн ажиллажээ.

Засгийн газрын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн 253 дугаар тогтоолын дагуу 39.9 сая төгрөгийн “Шивээговь сумын 3 дугаар сургууль, Говьсүмбэр аймгийн Лаборатори 5 дугаар сургуулийн дотуур байрны тавилга, тоног төхөөрөмжийн ажил”-ын санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна.



Бүлэг 1

Хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд
төлөвлөөгүйгээс хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга
хэмжээ батлагдсаар байна.

А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.

А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй бүрэн нийцээгүй байна.

Говьсүмбэр аймагт 2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-тай нийцсэн боловч хөрөнгө оруулалтын талаар баримталж буй нэгдсэн бодлого чиглэлтэй бүрэн нийцэхгүй байна. Тухайлбал:

1. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 19 төсөл, арга хэмжээний 16 нь буюу 84.2 хувь
2. Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 19 төсөл, арга хэмжээнээс 11 буюу 57.9 хувь нь тус тус нийцээгүй. /Хавсралт №1/

Энэ нь Төсвийн тухай хуулиар 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулахаар заасан байдагтай холбоотой байна.

Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд МУТХҮБ 2030-тай нийцэж байгаа боловч МУЭЗН-ийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй уялдаж чадаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №1 харуулав./

Орон нутагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүд нь улсын хэмжээнд баримталж буй бодлого чиглэлтэй нийцэхгүй байгаа шалтгаан нь салбарын ТЕЗ-д нь аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэдэггүй, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг харгалзаж үздэггүйтэй холбоотой байна. Тухайлбал: 2020 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 8,678.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээнээс 3,300.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ нь аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэсэн байна.

Говьсүмбэр аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дээрх 19 арга хэмжээний 7 буюу 36.8 хувь нь тусгагдаагүй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт №2-т харуулав./

Эдгээр нь хөрөнгө оруулалтын саналыг аймгийн ТЕЗ-аар дамжуулахгүйгээр салбарын ТЕЗ-д хандан шийдвэрлүүлж байгаатай холбоотой байна.

Тухайлбал: Боловсролын салбарт батлагдсан 118.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй, Боловсрол, соёл, урлагийн газраас салбарын сайдад саналаа хүргүүлсэн тул аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй байна.

Аймгийн хэмжээнд хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалт байхгүй, нэгдсэн байдлаар төлөвлөлт хийгээгүй зэрэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.12, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3 дугаар зүйлийн 3.3, 4 дүгээр зүйлийн 4.1, 4.5 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Цаашид аймгийн ТЕЗ-д нэгдсэн байдлаар төлөвлөлтийг хийж бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтыг бэлтгэн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.



А.1.2 Шинээр жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь ТЕЗ-ийн саналд бүрэн үндэслэж чадаагүй байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт шинээр хэрэгжихээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй байна.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн улсын төсвөөр хэрэгжүүлэх арга хэмжээний саналын нэгтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 1

/сая төгрөгөөр/

№	Санал хүргүүлсэн ТЕЗ	2020 онд шинээр хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн ТАХ-ний тоо	Төлөвлөсөн төсөвт өртөг	2020 онд шинээр хэрэгжихээр батлагдсан ТАХ- ний тоо	Хуулиар батлагдсан төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Үүнээс: аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэн	
							ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БХБС	7	4,797.1					
2	ЭХС	1	754.9					
3	ЭМС	1	1,500.0					
4	ЗТХС	1	1,241.0					
5	БСШУС	5	19,602.2	6	3,451.4	201.4	1	3,300.0
6	СоС	0	-	1	3,500.0	50.0	0	-
7	БОАЖС	1	783.3	2	80.0			
8	ШС	1	658.7	1	50.0			
9	УЕП			1	1,597.2	798.6	0	-
Нийт		17	29,337.21	11	8,678.6	1,050.0	1	3,300.0

Хүснэгтээс харахад: Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймгийн ТЕЗ нь шинээр хэрэгжүүлэх 17 төсөл, арга хэмжээг 29,337.2 сая төгрөгөөр хэрэгжүүлэх саналыг Сангийн яам болон харьяалах яамны ТЕЗ-д хүргүүлсэн бөгөөд 8,678.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ шинээр батлагдсан байна.

Батлагдсан 11 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээг Говьсүмбэр аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэсэн бол 5,378.6 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг үндэслээгүй байна.

Шивээговь сумын 3 дугаар сургуульд 2020 оны байдлаар 715 хүүхэд суралцдаг бөгөөд 640 хүүхдийн барилгыг 3,600.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр барих саналыг аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн боловч орон нутгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэлгүйгээр 320 хүүхдийн багтаамжтай, төсөвт өртгийг 3,300.0 сая төгрөг болгон тус тус бууруулж баталжээ.

А.1.3 ТЕЗ нь аймгийн 2020 оны хөрөнгө оруулалтын ажлыг холбогдох дүрэм журмын дагуу үнэлж, эрэмбэлээгүй байна.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ нь хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох ажлын хэсгийг байгуулаагүй, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу үнэлгээг хийж, эрэмбэлэхгүйгээр жагсаалтыг бэлтгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3, 3.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид батлагдсан аргачлал, журмын дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналыг бэлтгэх, үнэлж, эрэмбэлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

А.2 Төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна.



А.2.1 Төсвийн тухай хуульд нэр зааж батлагдаагүй зураг төсөл боловсруулах ажлыг барилгын ажлын гэрээний үнийн дүнд оруулан гүйцэтгүүлсэн, зарим төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагатай нийцэж чадаагүй байна.

2020 онд шинээр хэрэгжих 11 төсөл, арга хэмжээнээс зураг, төсөл боловсруулах шаардлагатай 2 төсөл, арга хэмжээ байгаа бөгөөд Шивээговь сумын 3-р сургууль, Прокурорын газрын барилгын ажил эрх шилжээгүй тул зураг төсөлтэй холбоотой баримт материалууд аудитад хамрагдаагүй.

ХХААХҮС-дад батлагдаж эрх шилжсэн ЖДҮ-ийг дэмжих төвийн барилгын ажил, ЗТХС-дад батлагдаж эрх шилжсэн “Аймгийн төвийн 3.4 км замын ажил”-уудын зураг төслийг Төсвийн тухай хуульд нэр зааж батлаагүй боловч гэрээний үнийн дүнд зураг төслийг боловсруулах ажлыг оруулан гүйцэтгүүлжээ.

Дээрх зураг төслийн ажлууд нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага болон холбогдох дүрэм журмын дагуу боловсруулагдсан байна.

Харин өмнөх оноос он дамжин хэрэгжиж буй 5,629.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сүмбэр сумын 640 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсвийг “Эй Эн И И” ХХК 2013 онд аймгийн ОНХС-гийн 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр 960 хүүхдийн багтаамжтай байхаар төлөвлөж ажлыг гүйцэтгээд байсан боловч аймгийн Засаг даргын 2017 оны 01 сарын 30-ны өдрийн ЗД-07/2017 тоот зураг төслийн ажлын даалгавраар хүүхдийн тоог 640 болгон бууруулж, нэмэлт 10.0 сая төгрөгийн гэрээ байгуулан шинээр зураг төсөл боловсруулж магадлалаар баталгаажуулсан бөгөөд энэ нь орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна.

Сургуулийн одоогийн хүчин чадал болон суралцагчийн тоог хүснэгтээр харуулбал:
Хүснэгт № 2

Д/Д	Сургуулийн нэр		Сургуулийн хүчин чадал	Суралцагчийн тоо	Зөрүү	Хувиар
1	Говьсүмбэр аймгийн сумын 1 дүгээр сургууль	Сүмбэр	640	1,126	486	76%
2	Говьсүмбэр аймгийн сумын 2 дугаар сургууль	Сүмбэр	320	745	442	147%
Нийт дүн			960	1,871	928	194.8

Хүснэгтээс харахад: Сүмбэр сумын 1 болон 2 дугаар сургуулийн ачаалал 928 хүүхэд буюу 94.8 хувиар хэтэрсэн байхад 640 хүүхдийн сургууль барих нь үр дүн муутай байна.

А.2.2 Барилга, байгууламжийн зураг төсөв зохиох зардлыг зохиогчийн бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-д зураг төсөл зохиох ажил батлагдаагүй боловч гүйцэтгэгчтэй байгуулсан барилгын ажлын гэрээний үнийн дүнд “ЖДҮ-ийг дэмжих төвийн барилгын ажил”, “аймгийн төвийн 3.4 км авто замын ажил”-ын зураг төслийг оруулан гүйцэтгүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн зураг төслийн гүйцэтгэгчийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 3

№	ТАХ-ний нэр	Шинэ	Шилжих	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч нэр	Гэрээний дүн	Зураг төсөл зохиогчийн нэр	Зураг төслийн гэрээний дүн	Олгосон дүн
1	Говьсүмбэр аймгийн төвийн 3.4 км авто зам		1	2,800.0	"Борхойн зам" ХХК	2,800.0	"Танил санаа" ХХК	39.0	39.0



2	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга угсралтын ажил	1	2,200.0	"Хан аттрибут" ХХК	2,149.5	"Нарлаг хүхий" ХХК	36.0	36.0
Нийт		2	5,000.0		4,949.5		75.0	75.0

Хүснэгтээс харахад: Улсын төсөвт нэр зааж батлагдаагүй боловч ажлын гэрээний дүнгээс нийт 75.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний зураг төслийг боловсруулж, зураг төслийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

А.2.3 Зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохиож, магадлалаар баталгаажуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говьсүмбэр аймагт хэрэгжих ТАХ-ний зураг төсвийг үнийн зохистой хэмжээг баримтлан зохиож, магадлалаар баталгаажуулсан байна.

А.3 Зарим төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төслийг төсвийн тухай хууль батлагдахаас өмнө боловсруулж, баталгаажуулаагүй байна.

А.3.1 Шинээр хэрэгжүүлсэн 7 төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд шинээр хэрэгжихээр батлагдсан 11 төсөл арга хэмжээнээс 7 /Хүснэгт-1/, шилжих 8 төсөл арга хэмжээнээс 2 /Авто зам, ЖДҮ барилга/ нь төсөвлөлтийн дараах шаардлагыг хангаагүй.

1. Аймгийн тухайн жилийн бодлого, үндсэн чиглэлтэй нийцээгүй.
2. Аймгийн ТЕЗ-ийн санал болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй.
3. Тухайн жилийн Төсвийн тухай хууль батлагдсаны дараа зураг төсвийг боловсруулж, магадлалаар баталгаажуулсан байна.

Хууль батлагдсанаас хойш зураг төслийг боловсруулж, магадлалаар баталгаажсан ТАХ-ний жагсаалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4						/сая төгрөгөөр/
№	ТАХ-ний нэр	Хуулиар батлагдсан төсөвт өртөг	ТЕЗ	Зураг, төсөл боловсруулсан эсэх	Магадлалын дүгнэлттэй эсэх	Тайлбар
1	Аймгийн төвийн авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,800.0	ЗТХС	Тийм	Тийм	3.4 км замаас 1.3 км замын магадлалын дүгнэлт жагсаалт батлагдсаны дараа хянагдсан.
2	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/	2,200.0	ХХААХҮС	Тийм	Тийм	Улсын төсөв батлагдсаны дараа зураг төсөв хийгдэж магадлалаар баталгаажсан.
Нийт		5,000.0				

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

А.3.2 Төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтөд удирдлагын системийг үр дүнтэй ашиглаагүй байна.



Говьсүмбэр аймгийн ХОХБТХ нь 2019 онд Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын системд 17 төсөл, арга хэмжээг оруулсан боловч Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-аар батлагдсан аргачлалын дагуу үнэлгээ хийж, эрэмбэлээгүй байна.

Шинээр батлагдсан 11 төсөл арга хэмжээнээс Сангийн яамны хөрөнгө оруулалтын удирдлагын системд “Шивээговь сумын 3-р сургуулийн барилга”-ын ажил орсон бөгөөд бусад 10 төсөл, арга хэмжээ ороогүй байна.

Цаашид шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу үнэлж, эрэмбэлэх, цахим системээр төсөвлөлтийг гүйцэтгэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

А.3.3 Төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож, санхүүжилтийг батлуулсан байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Говьсүмбэр аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 33,090.6 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ батлагдсанаас тайлант онд санхүүжих 14,360.8 сая, уг хуульд нэр зааж батлагдаагүй буюу салбарын ТЕЗ-д батлагдаж эрх шилжсэн 281.4 сая төгрөгийн 8, нийт 19 төсөл, арга хэмжээний 14,642.2 сая төгрөг батлагджээ.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ нь эрх шилжиж ирсэн шинээр болон шилжих хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээг 16,065.1 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан бөгөөд өмнөх онд 4,507.7 сая, тайлант хугацаанд 4,873.4 төгрөгийн санхүүжилт олгож, үүнээс 66.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийг дансанд байршуулсан байна.

Санхүүжилтийг төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож батлуулсан байна.

А.3.4 Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус арга хэмжээ төлөвлөгдөж батлагдаагүй байна.

Б.Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Бүлэг 2

Гүйцэтгэгч компаниуд хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй, захиалагч нь гэрээний үүргийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, хяналтын тогтолцоо оновчтой бус, хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан байна.

Б.1.1 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Орон нутагт шинээр хэрэгжих 11 төсөл, арга хэмжээнээс 9 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг салбарын ТЕЗ-ийн шийдвэрээр олгосон байна.

Говьсүмбэр аймагт 2020 онд 6 ТЕЗ-ийн багцад батлагдсан 9 төсөл, арга хэмжээ эрх шилжиж хэрэгжсэн байна.

ТЕЗ-дын эрх шилжүүлсэн хугацааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5		/сая төгрөгөөр/			
№	ТЕЗ-ийн нэр	УИХ, ЗГ-ын шийдвэр, огноо, дугаар	ТЕЗ-ийн шийдвэр, огноо, дугаар	Эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо	Төсөвт өртөг



1	БСШУСС	БСШУССайдын 2020.02.06-ны өдрийн № 1а/734, 2020.02.21-ний өдрийн А/96 дугаар тушаал	5	151.4
2	БХБС	УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн "Монгол улсын 2020 оны төсвийн тухай" хуулиар өөрчлөн баталсан 2 дугаар хавсралт БСШУССайдын 2020.02.06-ны өдрийн № 1а/734	1	3,500.0
4	УОК	Улсын онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн № 3019 дугаар тоот	1	50.0
5	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн № 2020/47 дугаар тоот	1	50.0
6	БОАЖС	БОАЖСайдын 2020.05.27-ны өдрийн № А/427 дугаар тушаал	1	30.0
Нийт			9	3,781.4

Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Б.1.2 ТАХ-г тайлант онд бүрэн хэрэгжих боломжийг хангахуйцаар ХАА-г зохион байгуулсан байна.

Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутагт эрх шилжиж хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулжээ. Үүнд: Нийт 9 төсөл, арга хэмжээний 11.1 хувь буюу 1 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт, 88.9 хувь 8 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар тус тус худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Үнэлгээний хороо байгуулсан хугацааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6

№	Үнэлгээний хороог байгуулсан огноо	Байгуулсан үнэлгээний хорооны тоо	Тайлбар
1	2020.02.27	7	Хугацаандаа байгуулагдсан.
2	2020.06.11	2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт орсон хугацаагаар байгуулагдсан.
3	2020.11.11	1	Эрх шилжүүлсэн хугацаагаар үнэлгээний хороо байгуулсан.
Нийт		9	

Хүснэгтээс харахад: Үнэлгээний хороо нь эрх шилжүүлсэн хугацаа буюу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тухай бүрд байгуулагдсан бөгөөд төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжтой хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Б.1.3 Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна.

Тайлант хугацаанд 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч "1 дүгээр сургуулийн барилгын засвар"-ын ажлыг эрх шилжүүлсэн БСШУС төсвийг буцаан татсанаар нийт 331.4 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг хязгаарлагдмал, 8 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар тендерийн баримт бичгийг боловсруулж, холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.



Б.1.4 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас аймгийн ТЕЗ-д шинээр эрх шилжин хэрэгжсэн 9 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж www.tender.gov.mn, www.haaa.gs.gov.mn гэсэн цахим хуудсанд байршуулж гүйцэтгэгчдийг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Мөн өдөр тутмын хэвлэл мэдээллийн “Монголын үнэн” сонинд тендер шалгаруулалтыг зарлаж, сонирхсон этгээд оролцох боломжийг хангаж ажиллажээ.

Доорх линкээр хандаж, Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газраас зарласан 2020 онд зарласан тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг авч болно.

<https://www.tender.gov.mn/mn/invitation?year=2020&selGovernorId=138&page=1&perpage=100&get=1>

Б.1.5 ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.

Говьсүмбэр аймгийн Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагааны мэдээ тайланг хууль журамд заасны дагуу тухай бүрд нь үнэн зөв тайлагнасан байна.

Худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хугацааны дотор буюу хагас жилийн тайланг 2020 оны 07 сарын 08-нд, бүтэн жилийн тайланг 2021 оны 01 дүгээр сарын 14-нд Сангийн яаманд тус тус хүргүүлжээ.

Б.2 Захиалагч гэрээний дагуу ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлээгүй, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллаагүй байна.

Б.2.1 Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний дагуу хугацаанд нь чанартай гүйцэтгээгүй байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд Говьсүмбэр аймагт шинээр хэрэгжих 9 төсөл, арга хэмжээнээс БСШУСС-ын багцаас эрх шилжсэн “Говьсүмбэр аймгийн Лаборатори 5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургуулийн дотуур байранд тавилга тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ыг хүлээн авсан гэж акт үйлдсэн боловч техникийн тодорхойлолт, тоо хэмжээнд заасан тоног, төхөөрөмж, эд хогшлыг нийлүүлээгүй байна.

Мөн Монгол улсын 2019-2021 оны төсвийн тухай хуульд ХХААХҮС-ын багцад батлагдаж Говьсүмбэр аймагт эрх шилжсэн “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга”-ын ажлын гүйцэтгэгч “Хан атрибут” ХХК-ийн 2019 оны гүйцэтгэлийн тайланд графикайн дагуу 1 давхрын цутгалт, 2 давхрын дам нуруу, хучилтыг хийсэн гэж гүйцэтгэл гаргасан боловч дээрх ажлууд одоо болтол хийгдээгүй бөгөөд цахилгаан, сантехникийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэсэн байна.

Ажлын гүйцэтгэлийг 30%-иар баталгаажуулсан боловч нийт санхүүжилтийн 46.5% буюу 1,000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Захиалагч болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч ГХБХБГ-ын зүгээс тус байгууллагад удаа дараа ажлаа гүйцэтгэх шаардлага хүргүүлсэн боловч гүйцэтгэгчийн зүгээс албан ёсоор хариу ирүүлээгүй байна.

Үүнээс үзэхэд гүйцэтгэгч компаниуд гэрээний хугацаанд ажлаа чанартай гүйцэтгэсэн гэж үзэх үндэслэлгүй байгаа бөгөөд хариуцлага тооцож ажиллахгүй байгаа нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, чанар үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Энэ нь Иргэний хуулийн 350 дугаар зүйл, захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг зөрчиж байх тул гэрээний үүргийг биелүүлж ажиллахыг гүйцэтгэгчээс шаардах, гэрээнд заасны дагуу алданги тооцох, хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх зэрэг шат дараалсан арга хэмжээ авч ажиллах тухай албан шаардлагыг захиалагч буюу аймгийн Засаг даргын тамгын газрын даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.



Б.2.2 Зарим төсөл, арга хэмжээний хувьд мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зохиогчийн хяналт үр дүн муутай байна.

Захиалагч нь захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх чиг үүрэгтэй бөгөөд Говьсүмбэр аймгийн ГХБХБГ-тай гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлсэн байна.

2020 онд ГХБХБГ нь улсын төсвийн шинээр болон шилжих хөрөнгө оруулалтын 10 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ.

Тайлант онд захиалагчийн хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажилласан байна.

Шилжих хөрөнгө оруулалтаар 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, захиалагчийн хооронд зохиогчийн хяналтын гэрээ байгуулахаас 5 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулагдсан байна.

Эдгээрээс дараах төсөл, арга хэмжээнд тавигдаж буй зохиогчийн хяналт үр дүн муутай, холбогдох журам зааварт нийцээгүй байна. Тухайлбал:

1. “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил”-ын зургийн зохиогч “Гандирс Од” ХХК нь талбайн журналд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн талаар тэмдэглэл үйлдсэн боловч барилгын ажлын гүйцэтгэл болон санхүүжилтийн баримтад зохиогчийн хяналтын тайланг гаргаж ирүүлээгүй. Өмнөх онд мөн дээрх зөрчлийг гаргаж байсан тул зохиогчийн хяналтын зардлыг олгоогүй.
2. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил”-ын зургийг зохиогч “Нарлаг хөхий” ХХК нь ажлын гүйцэтгэлийг үнэн зөвөөр баталгаажуулаагүй, бодитоор хяналт тавиагүй. Хийгдээгүй ажлуудыг актаар баталгаажуулсан байна.
3. “Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил”-ын зураг төслийг “Гэрэлт ундралтай” ХХК гүйцэтгэсэн боловч зохиогч компанитай гэрээ байгуулаагүй, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5, 38 дугаар зүйлийн 38.1.3, 38.1.4, 38.1.10, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.2.3, 4.2.10-т заасантай нийцээгүй байна. Иймд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Б.2.3 Хөрөнгө оруулалтаар авсан тоног төхөөрөмж хууль, эрх зүйн баримт бичигт туссаны дагуу хэрэглэгчдэд бүрэн хүрээгүй байна.

Соёлын сайдын багцад батлагдсан “Монгол соёл-Монгол хүмүүн” хөтөлбөрийн хүрээнд 48.3 сая төгрөгийн өртөгтэй 25 ширхэг зөөврийн компьютерийг гүйцэтгэгч “Ай Ти зон” ХХК-иас 2020 оны 12 сарын 21-нд хүлээн авсан боловч захиалагч буюу аймгийн ЗДТГ тодорхойгүй шалтгаанаар ашиглагч байгууллагад хүргүүлээгүй, агуулахад хадгалж байна.

БСШУСС-ын багцаас эрх шилжсэн 39.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Говьсүмбэр аймгийн Лаборатори 5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургуулийн дотуур байранд тавилга, тоног төхөөрөмж” авах ажлыг бүрэн хүлээн авсан гэж акт үйлдсэн боловч гүйцэтгэгч ажлыг бүрэн хүлээлгэн өгөөгүй байна.

Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хуульд батлагдаж он дамжин хэрэгжсэн 145.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Аймгийн төвийн гэрэлтүүлэг”-ийн ажлыг гүйцэтгэгч “Осо констракшн” ХХК-иас 2020 оны 12 сарын 14-ний өдрийн 2020/20 тоот ажил хүлээн авах актаар авсан боловч ашиглагч, эзэмшигч байгууллагад бүртгүүлээгүй байна.

Мөн захиалагчийн зүгээс ТЕЗ-аас эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний нэр, зориулалтыг зөрчиж техникийн тодорхойлолт баталсан байна. Тухайлбал:

1. БСШУСС-ын багцаас эрх шилжсэн 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил”, 23.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгт гэр цэцэрлэг худалдан авах ажил”-ын тоо хэмжээнд Сүмбэр сумын 1, 2, 5, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгт эд хогшил худалдан авч нэр зориулалтыг өөрчилсөн.
2. БСШУСС-ын багцаас эрх шилжсэн 33.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Усан спорт сургалтын барилгын сантехникийн засвар”-ын ажлын техникийн тодорхойлолтыг



цахилгааны болон дээврийн ажил болгон өөрчилж, ажлын тоо хэмжээнд БТСГ-ын дээврийн хэсэгчилсэн засварыг нэмж зориулалтыг өөрчилсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2018 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.26, 9.28 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон боловч хүлээн аваагүй, бүртгэлд тусгагдаагүй 233.8 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудад бүрэн хүлээлгэн өгч дансанд бүртгэх албан шаардлага өгч, ТЕЗ-аас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний нэр зориулалтын дагуу хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Б.2.4 Тайлант онд гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Б.3 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Б.3.1 Зохиогчийн хяналтын тогтолцоо үр ашигтай хэрэгжиж чадаагүй байна.

2020 онд зохиогчийн хяналтын 5, захиалагчийн хяналтын 10 гэрээ байгуулж, уг гэрээний дагуу зохиогчийн хяналтын зардалд 131.5 сая төгрөг олгохоос тайлант хугацаанд 58.4 сая, захиалагчийн хяналтын зардалд 251.6 сая төгрөг олгохоос тайлант хугацаанд 186.0 сая төгрөгийг тус тус олгосон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт № 3,4-т харуулав./

Зарим ажлын үе шатны хяналтыг үнэн зөв баталгаажуулаагүй, зохиогчтой гэрээ байгуулж хяналт тавиулаагүй байна. Үүнд:

1. “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга”-ын ажлын гүйцэтгэлийг зургийн зохиогч “Нарлаг хөхий” ХХК нь 1 давхрын цутгалт, 2 давхрын дам нуруу, хучилтыг хийсэн гэж актад гарын үсэг зурж баталгаажуулсан боловч уг ажил өнөөдрийг хүртэл хийгдээгүй.
2. “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил”-ын зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч “Гандирс од” ХХК үе шатны ажлуудад хэрхэн хяналт тавьж ажилласан талаар тайлан гаргаж баталгаажуулаагүй.
3. “Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил”-ын зураг төслийн зохиогч “Гэрэлт ундрал алтай” ХХК-иар хяналт тавиулаагүй байна.

Эдгээр нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5, 38 дугаар зүйлийн 38.1.3, 38.1.4, 38.1.10, Барилга хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.2.3, 4.2.10, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2, 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 10 дугаар зүйлийн 10.7.11 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд “Аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил”-ын зохиогчийн хяналтын зардал болох 1.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоож, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зохиогчоор хяналт тавиулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллах зөвлөмжийг захиалагч буюу аймгийн ЗДТГ-т өгөхөөр шийдвэрлэв.

Харин аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-тай байгуулсан захиалагчийн хяналт хэрэгжүүлэх гэрээнд 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг 100% ГХБХБГ-т төвлөрүүлэх гэрээ байгуулсан боловч аймгийн ЗДТГ нь 28.3 сая төгрөгийн хяналтын зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаараа хүлээн авчээ. Цаашид захиалагчийн хяналтын гэрээг баримталж ажиллах шаардлагатай байна.

Б.3.2 Тайлант онд төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.



Өмнөх аудитаар төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй зөрчил илэрч зөвлөмж өгч байсан бөгөөд тайланд онд дээрх алдаа зөрчлийг арилгасан байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд заасан болон салбарын ТЕЗ-аас эрх шилжин гэрээ байгуулан, санхүүжилтийг олгосон 15 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр авсан санхүүжилтийн дүн 12,278.4 сая, ажлын гүйцэтгэл 12,137.7 сая төгрөг бөгөөд ажлын гүйцэтгэл дунджаар 84.5 хувьтай байна.

Б.3.3 Засгийн газрын болон ТЕЗ-даас хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд Засгийн газар болон ТЕЗ-даас дотоод хяналт хэрэгжүүлдэггүй бөгөөд зөвхөн захиалагч болон зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байна.

Б.4 Барьцаа хөрөнгө дансанд байршуулсан төсөл, арга хэмжээний санхүүжилт бүрэн олгогдоогүй, ашиглалтад хүлээн авсан тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.

Б.4.1 Барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хангалтгүй тул санхүүжилт олгогдоогүй байна.

Тайлант оны арга хэмжээнээс БСШУСС-ын багцаас эрх шилжсэн “Говьсүмбэр аймгийн Лаборатори 5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургуулийн дотуур байранд тавилга тоног төхөөрөмж худалдан авах ажил”-ын 39.9 сая төгрөгийн ажлын санхүүжилтийг Засгийн газрын 2020 оны 253 дугаар тушаалын дагуу барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Говьсүмбэр аймгийн ТЕЗ-д 2019 онд эрх шилжин хэрэгжсэн боловч Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу 1,859.8 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан бөгөөд тайланд онд зарим төсөл, арга хэмжээний санхүүжилт олгогдоогүй байна. /Барьцаа хөрөнгийн дансны судалгааг хавсралт № 5-т дэлгэрэнгүй харуулав./

Тухайлбал:

1. “Үдэлт, угталтын хаалга”-ны ажлын 24.0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор олгоогүй.
2. “Орон сууцны тоглоомын талбайн тохижилт”-ын ажлын 29.0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлтэй холбоотой олгоогүй.
3. “Гэр бүл, хүүхэд, залуучуудын ордны барилгын зураг төсөв”-ын ажлын 10.0 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлтэй холбоотой олгоогүй байна.

Барьцаа хөрөнгийн данстай холбоотой ажил гүйлгээг тулган баталгаажуулахад Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд батлагдсан “Нэгдсэн эмнэлгийн газардуулга, барилга”-ын ажлын гэрээнд 0.3 сая төгрөгийн зохиогчийн хяналтын зардал тусгагдсан боловч дээрх ажил нь зураг төсөлгүй тул зохиогчийн хяналт олгох хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд барьцаа хөрөнгийн дансан дахь 0.3 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Б.4.2 2020 онд ашиглалтад орсон, төсөл арга хэмжээг бүртгэлд бүрэн тусгаагүй, улсын комисс ажиллаж хүлээн авсан тоног төхөөрөмж бүрэн хүчин чадлаараа ашиглагдахгүй байна.



2020 оны жилийн эцсийн байдлаар 6,601.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээн авч 12,985.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжсэн байна.

Улсын комисс ажиллаж хүлээн авсан Соёлын сайдын багцад батлагдсан “Монгол соёл-Монгол хүмүүн” хөтөлбөрийн хүрээнд 48.3 сая төгрөгийн өртөгтэй 25 ширхэг зөөврийн компьютер”, БСШУСС-ын багцаас эрх шилжсэн 39.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Говьсүмбэр аймгийн Лаборатори 5-р сургууль, Шивээговь сумын 3-р сургуулийн дотуур байранд тавилга, тоног төхөөрөмж”, Монгол улсын 2019 оны Төсвийн тухай хуульд батлагдаж он дамжин хэрэгжсэн 144.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Аймгийн төвийн гэрэлтүүлэг”-ийн ажлыг хүлээн авсан боловч эзэмшигч, ашиглагч байгууллагад бүртгүүлээгүй, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.

Цаашид улсын комисс хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, ашиглалтын байдалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 235.4 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах болон давтан гаргахгүй байх 4 зөвлөмж, 1.6 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 233.8 сая төгрөгийн 2 албан шаардлага өглөө.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөөгүй байна.
2. Төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна.
3. Зарим төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төслийг төсвийн тухай хууль батлагдахаас өмнө боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Бүлэг-2

1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан байна.
2. Захиалагч гэрээний дагуу ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлээгүй, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийн хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллаагүй байна.
3. Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.
4. Барьцаа хөрөнгө дансанд байршуулсан төсөл, арга хэмжээний санхүүжилт бүрэн олгогдоогүй, ашиглалтад хүлээн авсан тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Захиалагч буюу аймгийн Засаг даргын тамгын газарт:

1. Төсөл, арга хэмжээний саналыг хуулийн шаардлага хангахуйц байдлаар бэлтгэх, үнэлж, эрэмбэлэх, Сангийн сайдын баталсан журам заавар аргачлалыг мөрдөж, цахим системээр төсөвлөлтийг гүйцэтгэж ажиллах
2. Бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангуулах, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалтыг бэлтгэх
3. ТЕЗ-аас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээг нэр, зориулалтын дагуу хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах
4. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зохиогчоор хяналт тавиулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3118,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2021.04.29 № 01/548

танил _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлуудад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа "Аймгийн төвийн авто зам 3.4 км /говьсүмбэр, Сүмбэр сум/" ажлын хүрээнд 2.67 км авто замын зураг төсвийн ажил гүйцэтгүүлж, түүнээс 1.3 км замын ажлыг гүйцэтгүүлсэн тул тайлангийн 4 дүгээр хүснэгтэнд 2.67 км гэснийг 1.3 км болгож өөрчлүүлэх саналтай байна.

ДАРГА  Д СОДНОМ



Н.Б. Дарханбаатар
Саналыг тайланг
тусган, тайланг
зурган багасгаа-
нууцга
2021.04.29



ХӨЛБӨГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР:

Аймгийн Засаг даргын Тамгын газраас тайлангийн төсөлд өгсөн саналыг хянаж үзээд өөрчлөлт оруулах үндэслэлтэй гэж үзсэн тул дараах байдлаар өөрчлөлт оруулав.

№	ТАХ-ний нэр	Хуулиар батлагдсан төсөвт өртөг	ТЕЗ	Зураг, төсөл боловсруулсан эсэх	Магадлалын дүгнэлттэй эсэх	Тайлбар
1	Аймгийн төвийн авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2,800.0	ЗТХС	Тийм	Тийм	3.4 км замаас 1.3 км замын магадлалын дүгнэлт жагсаалт батлагдсаны дараа хянагдсан.
2	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/	2,200.0	ХХААХҮС	Тийм	Тийм	Улсын төсөв батлагдсаны дараа зураг төсөв хийгдэж магадлалаар баталгаажсан.
Нийт		5,000.0				



Улсын хэмжээнд баримталж буй бодлогын баримт бичигтэй нийцсэн эсэхийг тулган
баталгаажуулсан жагсаалт

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	ТЕЗ-ийн нэр	МУ-ын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	МУТХҮБ-2030	МУНЭЗ 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	ЗГҮАХ 2016-2020
A	1	2	3	4	5	7	8
1	XI.1.1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	БХБС	Нийцээгүй	2.3.1.Усны нөөцийн нэгдсэн менежмент зорилт-2	Нийцээгүй	Нийцээгүй
2	XI.1.2	Аймгийн төвийн гэрэлтүүлэг /Говьсүмбэр, Сүмбэр сум/	БХБС	Нийцээгүй	2.1.5.Дэд бүтцийн салбар зорилт-6	Нийцээгүй	Нийцээгүй
3	XII.1.1.66	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	БСШУ СС	Нийцсэн №19	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	11.2	3.2.3, 3.2.6, 6.6.2.1
4	XII.1.1.210	Сургуулийн барилга, 320 суудал /Говьсүмбэр, Шивээговь сум, 3 дугаар сургууль/	БСШУ СС	Нийцсэн №19	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	11.2	3.2.3, 3.2.6, 6.6.2.2
5	XII.1.1.177	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/	БСШУ СС	Нийцсэн №20	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	11.1	3.2.2, 6.6.1.2
6	XIII.1.3.1	"Монгол соёл-Монгол хүмүүн" төсөл хөтөлбөр /Говьсүмбэр/	СоС	Нийцээгүй	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	Нийцээгүй	Нийцээгүй
7	XIV.1.1.3	Аймгийн төвийн авто зам, 3.4 км /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ЗТХС	Нийцээгүй	2.1.5.Дэд бүтцийн салбар зорилт-6	Нийцээгүй	Нийцээгүй
8	XVI.1.3	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/	ХХААХ ҮС	Нийцээгүй	2.2.1.Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал зорилт-2	4	1.23
9	XVII.1.4	Сумын өмчлөлд олгох 6 кВт-ын шугам, КТПН байгуулж, цахилгааны эх үүсвэр /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ЭХС	Нийцээгүй	2.1.5.Дэд бүтцийн салбар зорилт-6	6.6	2.102
10	XVIII.1.8	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	ЭМС	Нийцээгүй	2.2.2.Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоо зорилт-1	15.7	6.6.3.1
11	XX.1.2	Прокурорын газрын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	УЕП	Нийцээгүй	2.4 Тогтвортой хөгжлийн засаглал	17.18	5.1.16, 5.3.5.12
12	БСШУ ССайд ын 2020.0	Цэцэрлэгийн барилгын засвар /Говьсүмбэр, 2 дугаар цэцэрлэг/	БШУЯ	Нийцээгүй	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	11.1	3.2.3, 3.2.6



13		Усан спорт сургалтын барилгын сантехникийн засвар	СоС	Нийцээгүй	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	Нийцээгүй	Нийцээгүй
14	БСШУССайдын 2020.02.21-ний өдрийн А/96 дугаар тушаал	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5-р сургууль, Шивээговь сумын дотуур байранд тавилга тоног төхөөрөмж худалдан авах ажил	БШУЯ	Нийцээгүй	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	Нийцээгүй	Нийцээгүй
15		Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил	БШУЯ	Нийцээгүй	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	Нийцээгүй	Нийцээгүй
16		Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгт гэр цэцэрлэг худалдан авах ажил	БШУЯ	Нийцээгүй	2.2.3 Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн зорилт-1	Нийцээгүй	Нийцээгүй
17	БОАЖСайдын 2020.05.27-ны өдрийн №А/427 дугаар тушаал	Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 1 уст цэг байгуулах	БОАЖ С	Нийцээгүй	2.3.1.Усны нөөцийн нэгдсэн менежмент зорилт-2	Нийцээгүй	Нийцээгүй
18	ОББ-г үндэсний хорооны 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн №2020/47	Говьсүмбэр аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	БОАЖ С	Нийцээгүй	2.3.3.Экосистемийн тэнцвэрт байдал зорилт-2	Нийцээгүй	Нийцээгүй
19	УОК-ын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн №3019 дугаар тоот	Аймгийн аюулгүйн нөөцөд нэмэлтээр өвсний нөөц бүрдүүлэх	ШС	Нийцээгүй	2.1.1.Хөдөө аж ахуйн салбар зорилт-4	Нийцээгүй	Нийцээгүй



Орон нутгийн бодлогын баримт бичигтэй нийцээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Хуулийн код	Төсөл, арга хэмжээний нэр	Засаг даргын 2016-2020 үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
1	XIII.1.3.1	“Монгол соёл-Монгол хүмүүн” төсөл хөтөлбөр /Говьсүмбэр/	Нийцээгүй	Нийцээгүй
2	XX.1.2	Прокурорын газрын барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	Нийцээгүй	Нийцээгүй
3	БСШУССайдын 2020.02.06-ны өдрийн № 1а/734	Цэцэрлэгийн барилгын засвар /Говьсүмбэр, 2 дугаар цэцэрлэг/	Нийцээгүй	Нийцээгүй
4	БСШУССайдын 2020.02.21-ний өдрийн А/96 дугаар тушаал	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5-р сургууль, Шивээговь сумын дотуур байранд тавилга тоног төхөөрөмж худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
5	БСШУССайдын 2020.02.21-ний өдрийн А/96 дугаар тушаал	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгт гал тогооны тоног төхөөрөмж худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
6	БСШУССайдын 2020.02.21-ний өдрийн А/96 дугаар тушаал	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 4-р цэцэрлэгт гэр цэцэрлэг худалдан авах ажил	Нийцээгүй	Нийцээгүй
7	Улсын онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн № 3019 дугаар тоот	Аймгийн аюулгүйн нөөцөд нэмэлтээр өвсний нөөц бүрдүүлэх	Нийцээгүй	16. Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.



Зохиогчийн хяналтын гэрээний дүн, гүйцэтгэл

№	ТАХ-ний нэр	Зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын нэр	Зохиогч байгуулсан гэрээний дүн	Олгосон		Нийт	Үлдэгдэл	Тайлбар
				2019	2020			
1	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилга угсралтын ажил	"ЭН ЭЙ ИИ" ХХК	48.16	16.46	18.81	35.27	12.89	
2	Говьсүмбэр аймгийн төвийн 3.4 км авто зам	"Классик роуд" ХХК "Ихэр мөнх" ХХК, "Танил санаа" ХХК	25.60	-	25.60	25.60	0.00	
3	Сүмбэр сумын 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах ажил	"Урбан Девелопмент Консалтинг Групп" ХХК	26.30	9.30	14.01	23.31	3.00	
4	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга угсралтын ажил	"Нарлаг хүхий" ХХК	18.40	8.50		8.50	9.90	
5	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга угсралтын ажил	"Гандирс од" ХХК	13.00	-		0.00	13.00	Зохиогчийн хяналтын тайлангүй.
Нийт			131.46	34.26	58.42	92.67	38.79	



Захиалагчийн хяналтын гэрээний дүн, гүйцэтгэл

№	ТАХ-ний нэр	Гэрээнд тусгагдсан зардлын дүн	ГХБХБГ		АЗДТГ		Хувь хүн хяналтын инженер	Нийт олгосон	Үлдэгдэл
			2019	2020	2019	2020			
1	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	52.53	13.0	19.6	5.6	8.4		46.6	6.0
2	Сургуулийн барилга, 640 суудал /Говьсүмбэр, Сүмбэр сум, 2 дугаар сургууль/	96.32	9.5	35.4	4.1	15.2		64.1	32.2
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/	25.96	-	18.2	-	-		18.2	7.8
4	Аймгийн төвийн гэрэлтүүлэг /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2.53	1.3	0.5	0.6	0.2		2.5	-
5	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Боржигон-эко төсөл/	36.71	11.9	-	5.1	-		17.0	19.7
6	Цэцэрлэгийн барилгын засвар /Говьсүмбэр, 2 дугаар цэцэрлэг/	0.00	-	-	-	-		-	-
7	Усан спорт сургалтын барилгын сантехникийн засвар	0.00	-	-	-	-		-	-
8	Чойрын хийдийн гол дуган, явган зам, тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум /	6.16	-	4.3	-	1.8		6.2	0.0
9	Үдэлт угталтын хаалга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	1.42	-	1.0	-	0.4		1.4	0.0
10	Орон сууцын тоглоомын талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар байр/	7.48	-	5.2	-	2.2		7.5	-
11	Говьсүмбэр аймгийн төвийн 3.4 км авто зам	22.50	5.5				17.0	22.5	-
Нийт		251.61	41.3	84.1	15.3	28.3	17.0	186.0	65.6



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа дансны судалгаа

№	Монгол Улсын 2019-2020 оны төсвийн тухай хуульд батлагдсан ТАХ-ний нэр	Гэрээний дүн	Барьцаа дансанд хийсэн.		Барьцаанаа с гаргасан.	Барьцаа дансны үлдэгдэл	Тайлбар
			2019	2020			
1	Орон сууцын тоглоомын талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар байр/	499.0	75.90		21.16	54.74	2021 онд 29.0 сая олгосон.
2	Шинэ хөдөө /Худаг гаргах/	197.1	11.80			11.80	5 хувь барьцаа
3	Шинэ хөдөө /Техник хэрэгсэл, зөөврийн чингэлэг/	67.7	3.40			3.40	5 хувь барьцаа
4	Шинэ хөдөө /Тоног төхөөрөмж/	76.8	23.00		19.19	3.81	5 хувь барьцаа
5	Шинэ хөдөө /	152.6	7.60			7.60	5 хувь барьцаа
6	Жижиг, дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	780.3	780.30		741.30	39.00	5 хувь барьцаа
7	Чойрын хийдийн гол дуган, явган зам, тохижилт	330.2	223.80		207.33	16.47	5 хувь барьцаа
8	Барилга байгууламжийг паспортжуулах	50.0	50.00		47.50	2.50	5 хувь барьцаа
9	2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/	3,424.3	1.20		-	1.20	Санхүүжилт
10	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум, 5 дугаар цэцэрлэг/	1,508.6	500.50		500.51	- 0.01	
11	Үдэлт угталтын хаалга	81.8	81.80		53.82	27.98	Ажлын гүйцэтгэлээс шалтгаалж санхүүжилт олгогдоогүй.
12	Сүмбэр сумын 2-р сургуулийн барилгын ажил	5,490.1	13.00		-	13.00	зохиогчийн хяналтын зардал
13	Нэгдсэн эмнэлгийн газардуулга, барилга	40.5	2.40		-	2.40	зохиогчийн хяналтын зардал
14	Сүмбэр сумын Найрамдал хотхоны 5,7,9,12 гадна зогсоол	170.0	12.10		3.60	8.50	5 хувь барьцаа
15	Боржигин чуулгын гаднах талбайн тохижилт	99.0	4.90		-	4.90	5 хувь барьцаа
16	Шинээр баригдах орон сууцны гадна шугам сүлжээ	300.0	15.00		-	15.00	5 хувь барьцаа
17	1-р сургуулийн биеийн тамирын талбайн тохижилт	249.9	16.60		2.28	14.32	1.8 сая төгрөгийн барьцаа илүү авсан.
18	Аймгийн төвийн дугуйн зам	387.7	26.40		7.00	19.40	
19	Гэр бүл, хүүхэд, залуучуудын ордны барилгын зураг төсөв	19.9	10.00		-	10.00	2021 оны 02.08-нд олгосон.
20	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын ерөнхий боловсролын 5-р сургууль, Шивээговь сумын дотуур байранд тавилга тоног төхөөрөмж худалдан авах ажил	39.9		39.9	0	39.90	
Нийт			1859.70	39.9	1603.71	295.89	